

**СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2023 оны 06 дугаар сарын мэдээлэл

2023.06.24.

“Овоот”

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

-2023.06.29 нд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит 12 дугаар хуралдааныг хуралдуулахаар товыг тогтоогоод хэлэлцэх асуудлын төсөлд санал авч байна. Үүнд:

А. Малын хөлийн тоо толгойн албан татварт сумын малчдын хаврын гамшгийн нөхцлөөс шалтгаалан мал ихээр хорогдсонтой холбоотой хөнгөлөлт үзүүлэх.

Б. Алтан овооны 110 жилийн ой болохтой холбогдуулан аялагчид жуулчдаас байгаль бохирдуулсны хураамж авах асуудал

В. Бусад.

-2023.06.17 нд Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Алтан овооны 110 жилийн ойн бэлтгэл ажлыг хангуулах талаарх санал солилцох албан ёсны анхны хурлыг хийж, тахилга тайлгын бэлтгэл ажлын ерөнхий чиглэлийг тогтоож, сумын Засаг дарга, Тамгын газар, бусад албан тушаалтанд үүрэг өгсөн.

-Сумын “Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох” төсөл сонгон шалгаруулах комисс хуралдаж 6 төсөлд 42 сая төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэв.

-Сумын Засаг даргын захирамжаар “Хөдөлмөрийн маргаан зохицуулах гурван талт хороо”-г 9 хүний бүрэлдэхүүнтэй томиллоо.

-Хууль эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр

-2023.05.29 -2023.06.15 ны “Шүгэл ажиллагааны аян” д нэгдэж Авлигатай тэмцэх газар болон аймгийн ХЭЗХ-ийн цахимд байршуулсан шторк болон бусад мэдээллийг шэйрлэж, сурталчлах ажиллагаанд төсвийн 5 байгууллага идэвхтэй оролцсон. Мөн төрийн байгууллагуудад ажлын байранд нь дараахь чиглэлээр сургалт, сурталчилгаа хийлээ. (Авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, Төрийн албан хаагчийн Ёс зүйн дүрэм, Нийгмийн даатгалын тухай мэдвэл зохих мэдлэг, ОНХС-ийн цахим санал авах ажиллагааны тухай, Татварын орлого бүрдүүлэлт, бусад цаг үеийн мэдээлэл)

-2023.06.07-2023.07.01 ний өдрүүдэд “Замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангах” зорилгоор бага насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудсаар сурталчилгаа хийх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

-Аймгийн БОГ-ын баг хамт олон 2023.06.13 наас 2 өдөр суманд ажиллаж, сургалт сурталчилгаа хийж, сумын ЗДТГ-тай хамтран ажиллалаа.

-2023.06.22 нд ТАЗ-ийн цахим сургалтад 5 байгууллагын төлөөлөл 8 албан хаагч хамрагдаж мэдээлэл авсан.

-2023.06.23 нд “ЧАДАМЖИД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА” гарын авлага танилцуулах цахим сургалтад ЗДТГ-ын холбогдох албан хаагчид хамрагдаж мэдээлэл авлаа.

Улсын хэмжээнд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах “БЭЛЭН БАЙ” аянд Дарьганга сумын ЕБС нэгдэж байна. Та утсандаа “Бэлэн бай гэсэн QR-ыг уншуулбал газар хөдлөлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй цэгийн байршил зэрэг мэдээллүүд гарч ирнэ”. Иргэн та ч мөн бэлэн байгаарай. [#Бэлэн бай](#) Олон нийтийн сүлжээн дэх найзууддаа түгээж [#belen bai](#) аянд нэгдэхийг уриалж, мөн орон даяар дуут дохиогоор ажиллах дадлага сургуулийг хийсэн.

Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Сумын Засаг даргын 2023.05.23 -ны өдрийн А/49 захирамжаар ажлын хэсэг 4 хэсэгт, 12 хүний бүрэлдэхүүнтэй томилогдон 2023.05.30 ны өдрөөс 06 сарын 06 ны хооронд тооллогын ажлыг амжилттай зохион байгууллаа. Тооллогод: 130 өрх, 1 аж ахуйн нэгж хамрагдав. Адуу-5100, үхэр -4304 , хонь-24129, ямаа-11904 ,тэмээ-75 нийт-45510 мал тоологдов. Малын зүй бусын хорогдлын хувьд: том малын хорогдол 18971, төлийн хорогдол-19220, нийт-38191 толгой малын хорогдолтой байна. Төл бойжилт 85% тай байна.

Гурав. СОЁЛ, БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

2022-2023 оны хичээлийн жилийн Элсэлтийн Ерөнхий шалгалтад:
Монгол хэлний хичээлээр 1 суралцагч 700-аас дээш
Химийн хичээлээр 1 суралцагч 600-аас дээш
Математикийн хичээлээр 3 суралцагч 600-аас дээш
Нийгмийн ухааны хичээлээр 3 суралцагч 600-аас дээш үнэлгээтэй шалгагдсан ба багш нар маань массаар нь амжилттай бэлтгэж өмнөх оны үнэлгээг 5 хичээл дээр ахиулж чадсан байна.

- МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан "ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН" үндэсний хөдөлгөөн, "ЦАГ ГАРГАЯ" аяны хүрээнд зохион байгуулагдсан "Итгэл, найдвар, боломж, Баруун-Урт- 2023" бүх нийтийн гүйлтийн 5км-ын уралдааны 18-39 насны ангилалд 11 а ангийн сурагч Б.Эрдэнэчулуун "Хүрэл медаль" хүртсэн.

Дөрөв. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн сайн малчин, МҮОНТелевизийн нэрэмжит Алтан унаганы эзэн Дарьганга сумын 2-р багийн малчин Ч.Төмөрбаатар иргэн хүний нийгмийн хариуцлагын хүрээнд сумын Эрүүл мэндийн төвийн Сэргээн засах эмчилгээний өрөөг тохижуулахад 1.500.000 төгрөгийн хандивлалаа.

Дэлхийн тамхины эсрэг өдрийг энэ жил “Бидэнд тамхи биш хүнс хэрэгтэй” уриан дор тэмдэглэн, "Тамхи ба тамхины донтолт" "Тамхинаас гарахад зөвлөгөө өгөх аргачлал" сэдвээр сургалтыг цахимаар явууллаа.

Тав. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

140 х 80 хэмжээтэй газарт 40,000,000 төгрөгний өртөгтэй хашаа татаж цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлж, хашаан дотор 1500ш мод тарьж усалгаа арчилгааг тогтмол хийж байна.

Хогийн цэгийн талбайн хэмжээг багасгах ажлын хүрээнд 20 сая төгрөг ИТХ аар батлуулан сумын нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх ажлыг ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлсэн 7хоног, 8 хүн ажиллаж хогийн цэгийн талбайн хэмжээг 0.5 гагаар багасгаж хүлээн авлаа.

Хөрсний бохирдолыг бууруулах зорилгоор “**Эко жорлон**” арга хэмжээний хүрээнд зэгст нуурын орчимд байсан модон жорлонг буулгаж АЗДТГ-аас 7 ширхэг эко жорлонг нуурын хойт урд тал байршуулсан

МЭДЭЭЛЭЛ БИЧСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН

ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР